



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А18

Улаанбаатар хот

### “Талын салхи-2024” олон улсын мото наадам арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/615 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох зорилгоор “Талын салхи-2024” олон улсын мото наадмыг 2024 оны 06 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбай болон Чингис хааны хөшөөт цогцолборт зохион байгуулсугай.

2.Наадмыг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж, шаардагдах 96,043,410 (ерэн зургаан сая дөчин гурван мянга дөрвөн зуун арав) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.


3.Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2024 оны 06 сарын 05 өдрийн  
...А/18... дугаар тушаалын хавсралт



“ТАЛЫН САЛХИ-2024” ОЛОН УЛСЫН МОТО НААДМЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ТӨСӨВ

2024 оны 05 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Ажиллах өдөр	Нэгж үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1.Талбайн тохижилтын зардал					
1.1	Лед дэлгэц, хөгжим техник, карказ, гэрэлтүүлэг (Чингис хааны хөшөөт цогцолбор)	Багц	2		25,000,000
1.2	Асар майхан түрээс (3*3)	70ш	1.5	165,000	11,550,000
1.3	Био 00 түрээс	20ш	2		10,000,000
1.4	Чингис хааны хөшөөт цогцолбор ашиглалтын зардал	Багц	2		15,000,000
1.5	Салют үйлчилгээ	1000	1 удаа		3,500,000
4. Зохион байгуулалтын зардал					
2.1	Эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээ	Багц	1		125,850
2.2	Онцгой байдал, аюулгүй байдлын зардал	Багц	1		1,083,800
2.3	Цагдаагийн хамгаалалт гарах зардал	Багц	1		1,756,000
2.4	Тээврийн цагдаагийн замын хөдөлгөөний зохицуулалтад шаардагдах зардал	Багц	1		1,027,760
2.5	Урлагийн тоглолтын зардал	Багц	1		15,000,000
2.6	Маркетинг, сурталчилгааны зардал	Багц	2 сар		12,000,000
Нийт					96,043,410